



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/8/СТА-ТТЗ

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум. Аймгийн
ЗДТГ-ын байр “А” корпус, 3
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: www.audit.mn

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр
Утас: 70333141 Цахим хаяг: UlambayrD@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Байгалмаа
Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn
Аудитор: J.Mungunshagai
Утас: Цахим хаяг: MungunshagaiJ@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/8/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.5.2 Авлага.....	11
3.5.3 Бараа материал.....	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.5.10 Орлогын данс.....	14
3.5.11 Зардлын данс.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	19
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал...22	22
Дараагийн аудитад сум хөгжүүлэх сангийн талаар, болон орон нутгийн орлогын гүйцэтгэл, төлөвлөлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.....	22
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	23
1. Авлагын данстай холбоотой асуудал:.....	23
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХСан	Орон нутгийн хөгжлийн сан
СХСан	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2-р баг, Утас/Факс: (976) 7033 3141, И-мэйл: arkhangai@audit.gov.mn Вэб сайт: www.audit.mn	ХАЙРХАН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Л.ЧОЙЖЖАНЦАН ТАНАА
2021.02.01 № 148	
танай _____-ны № _____-т	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хайрхан сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Хайрхан сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Бусад мэдээлэл	
<p>Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.</p> <p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia is positioned in the center. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТЫН АГЫН ГЭРЭГ" (State Audit Agency of Mongolia) and a central emblem. A handwritten signature in black ink is written over the stamp.

Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	639,890.2	635,976.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,511.0	99,676.8
33	АВЛАГА	374,799.5	349,938.0
35	БАРАА МАТЕРИАЛ	152,579.7	186,361.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,577,846.4	6,538,341.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,577,846.4	6,538,341.6
39200	Биет хөрөнгө	6,473,558.4	6,434,053.6
39300	Биет бус хөрөнгө	104,288.0	104,288.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,217,736.7	7,174,318.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,382.9	1,095.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,382.9	1,095.5
41300	Өглөг	21,382.9	1,095.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,196,353.7	7,173,222.8
51	Засгийн газрын хувь оролцоо	7,196,353.7	7,173,222.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,730,402.3	1,730,402.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,300,844.0	2,277,713.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,165,107.4	3,165,107.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,217,736.7	7,174,318.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,313,644.7	3,122,269.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	164,224.5	127,914.7
110	Орлогын албан татвар	73,487.1	94,373.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,487.1	94,373.8
113	Хөрөнгийн албан татвар	2,430.0	2,310.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	88,307.4	31,230.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,865.3	310,417.6

120	Нийтлэг татварын бус орлого	168,865.3	310,417.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,980,554.8	2,683,937.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,420,598.3	3,030,283.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,420,598.3	3,030,283.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,665,832.7	2,931,990.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,536,697.8	1,771,816.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,202.0	217,413.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	267,798.3	301,686.4
2104	Хангамж, бараа материалын зардал	69,885.3	89,625.7
2105	Нормативт зардал	100,859.4	103,056.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,560.0	12,955.3
2107	Томилолт, зочны зардал	6,088.4	3,926.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,774.2	19,288.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	461,967.3	412,222.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	754,765.6	98,293.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-106,953.6	91,985.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	78,979.3	115,116.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-185,932.8	(23,130.9)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,242,652.6	2,865,961.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	164,224.5	127,914.7
110	Орлогын албан татвар	73,487.1	94,373.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,487.1	94,373.8
113	Хөрөнгийн албан татвар	2,430.0	2,310.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	88,307.4	31,230.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,486.6	14,769.7
1181	Газрын төлбөр	68,656.4	5,402.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	13,164.4	11,058.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,873.2	58,648.6

120	Нийтлэг татварын бус орлого	97,873.2	58,648.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,980,554.8	2,679,398.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,033,398.4	2,687,795.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,033,398.4	2,687,795.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,277,076.8	2,587,892.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,539,677.8	1,759,317.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,844.0	231,124.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282672.6	308,311.4
2104	Хангамж, бараа материалын зардал	62,923.6	73,346.2
2105	Нормативт зардал	101,685.6	76,011.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,061.3	14,916.4
2107	Томилолт, зочны зардал	5,960.4	3,926.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур аамж	11,294.7	34,878.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,956.8	86,060.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	756,321.7	99,903.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	209,254.1	178,166.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	182,201.2	173,000.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	182,201.2	173,000.4
2200	Дотоод эх үүсвэрээр	182,201.2	173,000.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-182,201.2	(173,000.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-115,800.0	(18,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	115,800.0	18,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-88,747.0	(12,834.3)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	201,258.1	112,511.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,511.0	99,676.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,196,353.7	7,196,353.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,196,353.7	7,196,353.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0

19	Тайлант үеийн үр дүн	-23,130.9	-23,130.9
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,173,222.8	7,173,222.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,082,107.60	2,773,016.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,695,682.50	2,595,164.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,643,443.20	2,552,470.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,772,972.00	1,759,317.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,391.50	231,124.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	312,108.50	308,311.41
2104	Хангамж, бараа материалын зардал	73,611.30	63,726.34
2105	Нормативт зардал	94,578.30	74,511.81
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,286.40	18,491.40
2107	Томилолт, зочны зардал	5,261.60	3,926.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,459.80	30,165.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,773.80	62,895.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,239.30	42,693.85
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	168,044.10	159,852.36
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	218,381.00	18,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,082,107.60	2,780,055.64
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,817,348.80	1,757,576.60
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	897,954.60	930,323.28
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,202.20	39,201.39

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА АНААС	327,602.00	52,954.38
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үл дэгдэл	1.00	33,732.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.00	40,771.21
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,256.00	1,256.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	156.50	156.50
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	937.00	937.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	680.00	680.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	257.00	257.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	156.50	156.50

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,802.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,802.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,569.8
2104	Хангамж, бараа материалын зардал	9,619.8
2105	Нормативт зардал	1,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,712.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,737.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,232.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	408.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,824.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,802.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,802.3

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Л.Чойжжанцан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасах болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэв.

Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны зорилго нь Нутгийнхаа байгаль орчинг хамгаалан, хүний ба бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг жигд хөгжүүлсэн, нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх сум болох” зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Ажлын байрыг 2-3 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- ✓ Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Хайрхан сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд

захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Хайрхан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,055,009.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 30,550.1 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 112,511.0 мянга, эцсийн үлдэгдэл 99,667.8 мянган төгрөг болж 12,843.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
<u>Төрийн сангийн харилца</u>	112,511.0	99,667.8	(12,843.2)
Үүнээс байгууллагын төрлөөр			
Орон нутгийн ерөнхий орлого	78,778.6	58,905.6	(19,873.0)
Орон нутгийн хөгжлийн сан	29,743.2	6,228.6	(23,514.6)
Сум хөгжүүлэх сан	3,989.2	34,542.6	30,553.4
Дүн	112,511.0	99,667.8	(12,843.2)

Эх сурвалж: Хайрхан сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12,843.2 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл буурсантай холбоотой байна.

3.5.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 349,938.0 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 24,861.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
-----------------	-----------------------	------------------------	-------------------------------

ЗДТГазар	1,126.9	1,126.9	0
Сум хөгжүүлэх сан	373,526.6	346,903.7	(26,622.9)
Хүүхдийн цэцэрлэг	26.4	26.4	0
ЭМТөв	119.6	899.3	779.7
Соёлын төв		410.1	410.1
ИТХурал		122.8	122.8
Ахлах сургууль		448.8	448.8
Дүн	374,799.5	349,938.0	(24,861.5)

Эх сурвалж: Хайрхан сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 26,622.9 мянган төгрөгөөр буурсан бол төсөвт байгууллагуудын авлага 1,761.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсөвт байгууллагын авлагын эхний үлдэгдэл 1,279.9 мянгант төгрөг эцсийн үлдэгдэл 3,034.3 мянган төгрөг байна. Үүнээс Засаг даргын тамгын газрын хувь хүмүүсээс авах авлага 1126,9 мянган төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн НДШ-ийн авлага 26.4 мянган төгрөг, Ахлах сургуулийн НДШ-ийн авлага 448.8 мянган төгрөг, Соёлын төвийн НДШ-ийн авлага 410.1 мянган төгрөг, ИТХурал хувь хүмүүсээс авах авлага 122.8 мянган төгрөг, ЭМТөвийн НДШ-ийн авлага 899.3 мянган төгрөг байна. НДШ-ийн илүү төлөлт нь цалингийн нэгдсэн систем шинэчлэгдэнтэй холбоотой зөрүү үүссэн бөгөөд тайлагналын дараах үйл явцад бүрэн барагдсан гэсэн тайлбарыг сумын Санхүү албанаас өгсөөн.

Харин Сум хөгжүүлэх сангийн 346,903.7 мянган төгрөгийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 41 иргэнтэй холбоотой 205,479.0 мянган төгрөгийн хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 53 иргэнтэй холбоотой 141,424.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэхээр хугацаатай мэдэгдэл хүргүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл болох 53 иргэнтэй холбоотой 141,424.6 мянган төгрөгөнд зөвлөмж хүргүүлээ.
- Аудитаас Хүүхдийн цэцэрлэгийн ажиллагсадтай холбоотой 26.4 мянган төгрөгийн авлага бууруулах албан шаардлагыг хүргүүлсэн байна.
- ЭМТөвийн 2005 онд үүссэн хувь хүмүүсээс авах 119.6 мянган төгрөгийн авлагыг өнөөдрийг хүртэл барагдуулаагүйд аудитаас авлагыг барагдуулан ажиллах албан шаардлага хүргүүлээ.
- ЭМТөв нь жирэмсний амралттай хүний НДШ-ийг илүү тооцон шилжүүлсэнтэй холбоотой 779.7 мянган төгрөгийн шимтгэлийн авлага үүсгэсэн зөрчил төлбөийн акт тогтоолсон.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 152,579.7 мянга, эцсийн үлдэгдэл 186,361.9 мянган төгрөг болж, 33,782.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	12,356.6	18,451.5	6,094.9
Эм боох материал	8,707.5	14,802.4	6,094.9
Тусгай зориулалттай материал	3,649.0	3,649.0	
Хангамжийн материал	113,250.1	151,954.4	38,704.3

Мал амьтад	26,973.0	15,956.0	(11,017.0)
Дүн	152,579.7	186,361.9	33,782.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	37,161.7	48,889.4	11,727.7
ЗДТГ	55,960.8	76,072.8	20,112.0
ИТХ	528.9	528.9	0
Соёлын төв	3,916.6	4,861.0	944.4
Цэцэрлэг	18,825.6	15,918.1	(2,907.5)
ЭМТ	36,186.1	40,091.7	3,905.6
Дүн	152,579.7	186,361.9	33,782.2

Эх сурвалж: Хайрхан сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 26.2 хувь буюу мянган төгрөг 48,889.4 нь Ахлах сургуулийн, 40.8 хувь буюу 76,072.8 мянган төгрөг нь ЗДТГ-ийн, 8.5 хувь буюу 15,918.1 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 21.6 хувь буюу 40,091.7 мянган төгрөг нь ЭМТөвийн, 2.6 хувь буюу 4,861.0 мянган төгрөг нь Соёлын төвийн, 0.3 хувь буюу 528.9 мянган төгрөг нь ИТХурлын бараа материалууд байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 239,407.9 мянган төгрөгийн, хандив тусламжаар 14,950.7 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 38,860.0 мянган төгрөгийн материал авсан бөгөөд 259,436.4 мянган төгрөгийн материалыг зарцуулж нийт 186,361.9 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Эрүүл мэндийн төвийн СТАудитаар 13,880.0 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийг орлогод авч тайланд залруулга хийсэн

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,577,846.4 мянга, эцсийн үлдэгдэл 6,538,341.6 мянган төгрөг болж, 39,504.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,473,558.4	6,434,053.6	(39,504.8)
Биет бус хөрөнгө	104,288.0	104,288.0	
Дүн	6,577,846.4	6,538,341.6	(39,504.8)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	2,880,862.4	2,752,899.3	(127,963.1)
ЗДТГ	1,720,758.5	1,862,142.7	141,384.2
ИТХ	4,718.7	3,958.4	(760.3)
Соёлын төв	340,544.0	336,891.1	(3,652.9)
Хүүхдийн цэцэрлэг	1,136,463.5	1,142,467.0	6,003.5
ЭМТ	494,499.3	439,983.0	(54,516.3)
Дүн	6,577,846.4	6,538,341.6	(39,504.8)

Эх сурвалж: Хайрхан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 51,680.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хандиваар авсан 57,434.9 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 186,685.0 мянган төгрөгийн,

нийт 289,800.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол тайлант онд 5,746.2 мянган төгрөгийн хөрөнгө актлаж устгасан байна.

Нийт хөрөнгийн 28.5 хувь буюу 1,862,142.7 мянган төгрөг нь ЗДТГазрын, 42.1 хувь буюу 2,752,899.3 мянган төгрөг нь Ахлах сургуулийн, 5.2 хувь буюу 336,891.1 мянган төгрөг нь Соёлын төвийн, 6.7 хувь буюу 439,983.0 мянган төгрөгийг ЭМТөвийн, 17.4 хувь буюу 1,142,467.0 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн хөрөнгүүд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Ахлах сургуулийн үндсэн хөрөнгөнд 2541.5 ширхэг элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүд
- ИТХурлын үндсэн хөрөнгөнд 17 нэр төрлийн 3,628.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүд
- ЗДТГазрын үндсэн хөрөнгөнд нийт 114,935.1 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүд
- Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд 33,562.7 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүд байгаад аудитаас Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, эд хөрөнгийн үнийг зөвшилцөн тогтоох үед УСНББОУС-23, "Арилжааны бус орлого гэсэн стандартын 42, 44 дүгээр параграфийн дагуу орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХ-ийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжүүдийг хүргүүлсэн.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,196,353.7 мянга, эцсийн үлдэгдэл 7,173,222.8 мянган төгрөг болж, 23,130.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 5. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯН.ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	1,730,402.3	1,730,402.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,300,844.0	2,277,713.1	(23,130.9)
Өмнөх үеийн үр дүн	2,300,844.0	2,300,844.1	(23,130.9)
Тайлант үеийн үр дүн		(23,130.9)	(23,130.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний	3,165,107.4	3,165,107.4	0.0
Дүн	7,196,353.7	7,173,222.8	(23,130.9)

Эх сурвалж: Хайрхан сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 23,130.9 мянган төгрөгөөр буурч тайлагнагдсан байна.

3.5.10 Орлогын данс

Хайрхан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,122,269.8 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 191,374.8 мянган төгрөгөөр буурсан байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 127,914.7 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 310,417.6 мянган төгрөг байна. Үүнээс: төсөвт байгууллагын өөрийн орлого 8,331.5 мянган төгрөг, нийтлэг татварын бус орлого 3,490.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 296,391.7 мянган төгрөг, бусад орлого буюу нэр заагдаагүй бусад орлого 2,203.6 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 2,683,937.5 мянган төгрөг байна. Үүнээс: Улсын төсвөөс 1,810,765.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 56,341.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 777,629.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 39,201.4 мянган төгрөг байна.

3.5.11 Зардлын данс

Хайрхан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 3,030,283.9 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 115,116.8 мянган төгрөг нийт 3,145,400.7 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос (23,130.9) мянган болж 162,801.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант жилд 548,200.6 мянган төгрөгийн санхүүжилт, 24,725.2 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Хүүхдийн цэцэрлэг нь цалингийн зардлаас 534.2 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд олгож зардлыг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлээ.
2. Мөн тус цэцэрлэг нь санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байсанд аудитаас зөвлөмж хүргүүлсэн байна.
3. ЗДТГазар нь ажилчдад цалин хөлсийг илүү тооцсон, улсын төсвийн байгууллагын албан тушаалтанд урамшуулал олгосон зэрэг нийт 3,023.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
4. Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2018 оны 318 тоот тогтоолоор баталсан Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 3.1-д заасны дагуу засаг даргын зөвлөл хуралдаагүй зарцуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
5. ИТХурал нь ЗДТГазрын орон тооны ажилтан Санхүү албаны даргад 300.0 мянган төгрөгийн цалингийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
6. ЗДТГазар, ИТХурал нь тайлант онд санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байсанд аудитаас зөвлөмж хүргүүлсэн байна.
7. Ахлах сургуулийн нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн 51,263.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөвлөмж хүргүүлсэн.
8. ЭМТөвийн цалингийн тооцооллыг давтан шалгахад 295.9 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ Орон нутгийн төсвийн орлогын талаар:

Орон нутгийн төсвийн орлогыг 83,852.0 мянган төгрөгөөр төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг сумын ИТХурлын 2019.12.13-ний өдрийн 6 тоот

тогтоолоор 13,370.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 97,582.3 мянган төгрөгөөр анх баталсан байна. Орлого өсгөн баталсан гол шалтгаан нь хог хаягдлын хураамж үйлчилгээний хураамж , хүү торгуулийн орлогыг тус тус нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогыг сумын ИТХурлын 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 08 тоот тогтоолоор 122,825.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Харин гүйцэтгэлээр 137,108.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 111.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Төвлөрүүлэх орлого

/мян. төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	2 200,0	1 671,6	(528,4)	76,0
2	Шууд бус орлого	18 900,0	40 413,7	21 513,7	213,8
3	Хадгаламжийн хүүгийн орлого	42 000,0	52 054,0	10 054,0	123,9
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150,0	234,5	84,5	156,3
5	Бууны татварын орлого	3 270,0	2 310,0	(960,0)	70,6
6	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	3 300,0	3 003,2	(296,8)	91,0
7	Газрын төлбөр		999,1	999,1	100,0
8	Газрын дуудлага худалдааны орлого	15 000,0	4 403,6	(10 596,4)	29,4
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	385,0	385,0	-	100,0
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	13 200,0	11 381,5	(1 818,5)	86,2
11	Ойн нөөц ашигласны төлбөр	10 890,0	11 028,5	138,5	101,3
12	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	30,0	30,0	-	100,0
13	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2 500,0	3 499,0	999,0	140,0
14	Хүү торгуулийн орлого	10 000,0	3 490,7	(6 509,3)	34,9
15	Нэр заагдаагүй бусад орлого	1 000,0	2 203,6	1 203,6	220,4
	Дүн	122 825,0	137 108,0	14 283,0	111,6

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч дараах нэр төрлийн орлогууд тасарсан байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны орлого 528.4 мянган төгрөгөөр тасарсан нь сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд нь аж ахуй нэгж үүсгэн үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой
2. Бууны албан татварын орлого 960.0 мянган төгрөгөөр тасарсан нь сумын татварын байцаагчийн судалдгаа, аймгийн Цагдаагийн газрын судалгаанууд зөрүүтэйгээс үүссэн
3. Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 296.8 мянган төгрөгөөр тасарсан нь аймагт төвлөрдөг болсонтой холбоотой

4. Газрын дуудлага худалдааны орлого 10,596.4 мянган төгрөгөөр тасарсан нь аялал жуулчлалын газрын анхны үнэ өндөр мөн дуудлага худалдааг 2-3 удаа явуулсан боловч оролцох иргэн аж ахуй нэгжгүйгээс тасарсан
5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,818.5 мянган төгрөгөөр тасарсан нь хураамж төлөхөөс татгалзсан өрх их учир тасарсан
6. Хүү торгуулийн орлого 6,509.3 мянган төгрөгөөр тасарсан нь иргэн аж ахуй нэгжүүдээс илэрдэг зөрчлүүд багассантай холбоотой, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн орлого шууд аймгийн дансанд ордог болсонтой холбоотой гэсэн тайлбарыг сумын Санхүү албаны дарга өгсөн.

Дээрхээс ажиглалал: Үйл ажиллагааны орлого, бууны албан татварын орлого, улсын тэмдэгтийн хураамж, хүү торгуулийн орлогууд тасарсан шалтгаан нь тухайн ТЭЗахирагчийн үйл ажиллагаанаас хамааралгүй байна гэж үзлээ харин хог хаягдлын үйлчилгээний хураамжийг өрх бүрээс бүрэн аваагүйгээс мөн газрын дуудлага худалдааны орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн, дуудлага худалдааны анхны үнийг буруу тооцсон учир орлого тасарсан байна гэж үзлээ. Иймд аудитаас орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх, орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөн ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. Төсвийн төлөвлөлт

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан мөнгөн дүн	Тодотгон баталсан мөнгөн дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	95,082.3	120,325.0	25,242.7
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	226,860.0	226,860.0	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	396,062.1	370,268.1	(25,794.0)
4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	95,357.5	91,602.1	(3,755.4)
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	2,265,765.7	2,172,310.4	(93,455.3)
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	70,998.8	70,998.8	-
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	37,607.0	29,743.2	(7,863.8)
Нийт дүн		3,187,733.4	3,082,107.6	(105,625.8)
Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	66,701.8	66,701.8	-
2	Засаг даргын тамгын газар	497,941.4	497,390.1	(551.30)
3	Орон нутгийн хөгжлийн сан	132,964.5	121,345.3	(11,619.20)
4	Сум хөгжүүлэх сан	222,710.0	222,710.0	-
5	Сургуулийн өмнөх боловсрол	427,591.4	375,572.9	(52,018.50)
6	Ерөнхий боловсролын сургууль	1,244,189.7	1,204,084.8	(40,104.90)

7	Соёлын төв	152,433.4	152,433.4	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	443,201.2	441,869.3	(1,331.90)
Нийт дүн		3,187,733.4	3,082,107.6	(105,625.8)

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн шууд бус орлогыг 17,600.0 мянган төгрөгөөр нэмж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 915.0 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 1,244.3 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг 198.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Тодотголоор дараах байгууллагуудын зардлыг хасч баталсан байна. Үүнд:

1. ЗДТГазрын зардлыг 551.3 мянган төгрөгөөр,
2. ОНХСангийн зардлыг 11,619.2 мянган төгрөгөөр.
3. Эрүүл мэндийн төвийн зардлыг 1,331.9 мянган төгрөгөөр хассан байна

Мөн Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн буюу ЕБСургууль, СӨБоловсролын байгууллагын үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор хүүхдийн хоол, үдийн цай болон бусад зардлуудыг нийт 92,123.4 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэл

Хайрхан сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолоор 3,187,733.4 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 17 тоот тогтоолоор ЗДТГ-г 551.3 мянган төгрөгөөр, ОНХСанг 11,619.2 мянган төгрөгөөр, СӨБ-г 52,018.5 мянган төгрөгөөр, ЕБС-г 40,104.9 мянган төгрөгөөр, ЭМТөвийг 1,331.9 мянган төгрөгөөр хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг 3,082,107.6 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,082,107.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,695,682.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 168,044.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 218,381.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,817,348.8 мянган төгрөг буюу 58.9 хувийг улсын төсвөөс, 897,954.6 мянган төгрөг буюу 29.1 хувийг орон нутгийн төсвөөс, 39,202.0 мянган төгрөг буюу 1.3 хувийг ЭМД-аас, 327,602.0 мянган төгрөг буюу 10.7 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,773,016.8 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь урсгал зардал 100,518.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 8,191.8 мянган төгрөг өөр хэмнэгдсэн, СХСангийн эргэн төлөлт 200,381.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХСангийн хөрөнгөөр 6 төсөл, арга хэмжээнд нийт 115,116.7 мянган төгрөг зарцуулагджээ. Үүнд: барилга байгууламжид 100,800.0 мянган төгрөг, бусад арга хэмжээнд 14,316.7 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 103.1 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 51,699.2 мянган төгрөг нийт 51,802.3 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан байна. Үүнээс Эрүүл мэндийн төв 1,688.1 мянган төгрөг, ЗДТГазар 47,728.7 мянган төгрөг, Ахлах сургууль 1,977.0 мянган төгрөг, Соёлын төв 408.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 125 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГазар нь тайлант онд шилэн дансны цахим сайтад 110 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 19 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан тул аудитаас албан шаардлага хүргүүлсэн байна.
2. Хүүхдийн цэцэрлэгийн шилэн дансны цахим сайтад 37 мэдээг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш 7 ажил гүйлгээ болох 44,670,016 төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
3. Ахлах сургууль шилэн дансны цахим сайтад 146 мэдээлэл оруулахаас 37 мэдээлэл хугацаа хоцроосон байршуулсан тул аудитаас албан шаардлага хүргүүллээ.
4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 125 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсанд аудитаас албан шаардлага хүргүүлсэн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар 139,049.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	5,383.0	1	5,383.0	
Зөвлөмж	1	129,010.0	1	129,010.0	0
Нийт	2	134,393.0	2	134,393.0	0

Хүснэгтээс харахад СХСангийн 129,010.0 мянган төгрөгийн зөвлөмж, 5,383.0 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлт хангалтгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Хайрхан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Батцэнгэл сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо			Аудитын санал дүгнэлтийн төрөл	
	Аудитад хамрагдсан	Үүнээс		Бүгд	Үүнээс
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй
Ахлах сургууль	1	1		1	1
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1	1
ЗДТГ	1		1	1	1
ИТХурал	1	1		1	1
Эрүүл мэндийн төв	1	1		1	1
Соёлын төв	1		1		
ОНХС	1		1		
СХС	1		1		
НИЙТ ДҮН	8	5	3	5	5

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 төсөвт байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, соёлын төв, 2 төсөл санг түүвэрт хамруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 269,059.4 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч аудитын явцад 14,894.0 мянган төгрөгийн залруулга хийж, 203,389.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 46,377.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,399.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Үүнээс				Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахлах сургууль	4	52,277.1	1	1,014.0	3	51,263			1		2	51,263.1
Хүүхдийн цэцэрлэг	5	79,632.4			5	79,632			3	46,069.7	2	33,562.7
ЗДТГ	6	117,958.4			6	117,958	1	3,023.4	1		4	114,935.0
ИТХурал	3	3,928.5			3	3,929	1	300.0			2	3,628.5
Эрүүл мэндийн төв	4	15,263.0	1	13,880.0	3	1,383	1	1,075.6	1	307.4	1	
Соёлын төв	-	-			-	-						
НИЙТ ДҮН	22	269,059.4	2	14,894.0	20	254,165.4	3	4,399.0	6	46,377.1	11	203,389

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 133,457.5 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 4,399.0 мянган төгрөгийн болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 131,202.9 алдаа зөрчил тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Хайрхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 153,839.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүнд: Орон нутгийн орлогын 2 нэр төрлийн орлого 12,414.9 мянган төгрөгөөр тасарсан, Шилэн дансны цахим сайтад 31 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан, СХСангийн чанаргүй болон хугацаа хэтэрсэн 53 иргэнтэй холбоотой 141,424.6 мянган төгрөгийн зээл байна.

Хүснэгт №11 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/




Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс			
			Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	1	141,424.6			1	141,424.6
Нэгдсэн тайлан	2	12,414.9	2	12,414.9		
НИЙТ ДҮН	3	153,839.5	2	12,414.9	1	141,424.6

1. Сум хөгжүүлэх сангийн 346,903.7 мянган төгрөгийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 41 иргэнтэй холбоотой 205,479.0 мянган төгрөгийн хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 53 иргэнтэй холбоотой 141,424.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл байгаад аудитаас зөвлөмж хүргүүллээ.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлэл зохих 156 мэдээллээс 125 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсанд аудитаас албан шаардлага хүргүүллээ.
3. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын дуудлага худалдааны орлого 12,414.9 мянган төгрөгөөр тасарсан. Энэ нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг өрх бүрээс бүрэн аваагүйгээс мөн газрын дуудлага худалдааны орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн, дуудлага худалдааны анхны үнийг буруу тооцсон учир орлого тасарсан байна гэж үзлээ. Иймд аудитаас орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх, орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөн ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Аудитын явцад Сангийн яамны э-тайлан цахим хуудсанд шивэгддэг Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн орон нутгийн төсвийн санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлгийн цэвэрлэх буюу устгах бичилтыг буруу хийсний улмаас аудитлагдсан санхүүгийн тайлан гаргахад хүндрэл бэрхшээл учирч аудитын хугацаа 3-4 хоногээр хоцорсон болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад сум хөгжүүлэх сангийн талаар, болон орон нутгийн орлогын гүйцэтгэл, төлөвлөлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

АУДИТЫН ТАЙЛАН			
Бэлтгэсэн:	Аудитор		Ж.Мөнгөншагай
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор		Д.Уламбаяр

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал:

- 1.1. **Илрүүлэлт:** Авлагын бүртгэлийг тулган үзэхэд Сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 205,479.0 мянган төгрөг байгаа бол 53 иргэнтэй холбоотой 141,424.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл байна.
- 1.2. **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авах. Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хайрхан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021.03.25			АРА-2021/8/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хайрхан сумын ТЕЗ		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Сум хөгжүүлэх сангийн 53 иргэнтэй холбоотой 141,424.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл	141,424.6	Албан шаардлага	Засаг дарга, Санхүү албаны дарга	Л.Чойжжанцан Д.Байгалмаа
2	Хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын дуудлага худалдааны орлого 12,414.9 мянган төгрөгөөр тасарсан.	12,414.9	Зөвлөмж өгөх		
3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 125 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан		Албан шаардлага		
	ДҮН	130,352.7			